

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө										
Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Санхүүжилт	Зорилтот түвшин 2026 он	Үндсэн эсэх	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилт	Хүрсэн түвшин
2. Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.										
2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.										
	2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	2.5.2.1. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	3		100	Үгүй	ХБ	-Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбож, өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангасан ба нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр тус яамыг 96%-иар үнэлсэн. -Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчлэн ажиллаж байна. -Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2026 оны жилийн эцсийн тайлан 12-р сарын 25-ны дотор тайлагнана.	
2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.										
	2.6.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.	2.6.2.1. Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлан төлөвлөгөө хэрэгжүүлэх	Тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын Шударга байдлын үнэлгээний онооны өсөлт	-	20 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Тийм	ХБ	Авлигатай тэмцэх үндсэний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус салбарт хамаарах арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан байгууллагад тус яам байхгүй болно.	
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.										
3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.										
	3.2.3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	3.2.3.2. Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны өсөлт	5	40 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Үгүй	ХБ	Нийтийн сонсголын тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд тус тус заасан төрөл, хэлбэрээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хамаарах нийтийн сонсгол зохион байгуулагдаагүй болно. Нийтийн сонсголын тухай хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна. Тус салбарт хамаарах асуудал байхгүй.	
3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.										
		3.3.1.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн ажлын хэсгийн нийт гишүүдийн тоонд эзлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	-		20	Үгүй	ХБ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх арга хэмжээ хамаарахгүй болно.	

[illegible]

	4.2.4. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангана.	4.2.4.8. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	Стандарт нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр ажиллаж байгаа хуулийн этгээд	-	200 Улсын төсөв, бусад эх үүсвэр	5	Үгүй	ХБ	Төрийн үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэх зорилгын хүрээнд БХБЯ 2021 оны 11 дүгээр сараас Олон улсын "Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015" стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. 2023.12.14 ний өдөр тус яам Төрийн захиргааны төв байгууллагуудыг манлайлан түүчээлж Олон улсын "Чанарын менежментийн тогтолцооны стандарт ISO 9001:2015"-ыг нэвтрүүлэлтийн Гэрчилгээг гардан авлаа. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд "ISO 9001:2015" стандартыг нэвтрүүлэх ажил 2 жилийн хугацаанд үргэлжилсэн, тус хугацаанд бэрхшээлтэй асуудлууд тулгарч байсан ч Төлөвлөх-Гүйцэтгэх-Шалган нягтлах-Сайжруулах гэсэн 4 үе шатны дагуу стандартыг нэвтрүүлж алдаа, дутагдал, сул тал, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр байнгын сайжруулалт хийж ажилласны үр дүнд баталгаажуулалтын Гэрчилгээг гардан авсан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны харьяанд төрийн өмчит хуулийн этгээд байхгүй болно.	
6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.										
6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.										
	6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.	6.4.11.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	70.1	300	100	Тийм	ХБ	Авлигатай тэмцэх үндсэний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус салбарт хамаарах арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Авлигатай тэмцэх үндсэний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд хэрэгжүүлэхээр тусгагдсан хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хамаарах арга хэмжээний 2026 оны эхний 8 сарын хэрэгжилтийн тайланг авлигын эсрэг үндсэний цахим сүлжээний цахим сан http://khutulbur.iaac.mn/iaac/-д баталгаажуулсан. Онцлох ажил: Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн нэгдсэн систем буюу "License.mn"-д шилжүүлсэн.	
7. Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.										
7.1. Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.										
	7.1.2. Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв захирагчдаар нийтлэхээс гадна эдийн засгийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.	7.1.2.1. Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар харуулах тусгах	Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны Жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт	39		45	Үгүй	100%	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; гэж тус тус заасны дагуу төсвийн шууд захирагчийн төсвийн мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим хуудаст тухай бүр хугацаанд нь ил тод байршуулж байна.	

		7.1.2.2. Төсвийн тухай хууль дахь төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх	Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны Жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт	39		45	Үгүй	100%	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; гэж тус тус заасны дагуу төсвийн шууд захирагчийн төсвийн мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим хуудаст тухай бүр хугацаанд нь ил тод байршуулж байна.	
7.3. Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.										
	7.3.2. Засгийн газрын тусгай сангийн хэрэгцээ, шаардлага, хуримтлал, удирдлага, зарцуулалтыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгоно.	7.3.2.1. Засгийн газрын тусгай сангийн хэрэгцээ, шаардлага, хуримтлал, удирдлага, зарцуулалтыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгох	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомж	-		1	Үгүй	ХБ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны харьяанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан тусгай сан байхгүй болно.	
	7.3.3. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох, эрсдэлийн үнэлгээг тодорхой хугацаанд давтамжтай хийж, аудитын үр дүнгээр нийтийн сонгол зохион байгуулна.	7.3.3.1. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох арга хэмжээ авах	Арга хэмжээ	-		3	Үгүй	ХБ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны харьяанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан тусгай сан байхгүй болно.	
	7.3.4. Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	7.3.4.1. Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлэх, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомж	2		1	Үгүй	ХБ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй болно.	

	7.3.6. Гадаадын зээл, тусламжийн бүртгэлийг төрийн санхүүгийн удирдлагын системд нэгтгэж, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулна.	7.3.6.1. Гадаадын зээл, тусламжийн бүртгэлийг төрийн санхүүгийн удирдлагын системд нэгтгэх	Нэгдсэн систем	1		1	Үгүй	100%	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 6 төслийн хүрээнд гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг цаг тухайд нь хянан баталгаажуулж, Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үүнд: "Ногоон нуур 1008 айлын орон сууц барих төсөл"-ийн гадаад тусламжийн санхүүжилт 40,019.12 сая төгрөг буюу 99 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 837.14 сая төгрөг, "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 6,758.03 сая төгрөг буюу 82 хувийн гүйцэтгэлтэй, "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 29,152.70 сая төгрөг буюу 36 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 1,460.21 сая төгрөг, "Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 45,925.70 сая төгрөг буюу 51 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 2,676.42 сая төгрөг, "Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 39,781.61 сая төгрөг буюу 46 хувийн гүйцэтгэлтэй, "Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн, шинэчлэх, шинээр барих (Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс) төсөл"-ийн гадаад зээлийн санхүүжилт 10,264.49 сая төгрөг буюу 53 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын санхүүжилт 1,108.16 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна.Төсөл хэрэгжүүлэх 4 нэгжийн 04 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг хянан баталгаажуулан Сангийн яаманд 2025.10.17-ны өдрийн 02/3865, 02/3866,
9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.									
9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.									
	9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.	9.5.2.1. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	-	150 "Улсын төсөв, бусад эх үүсвэр"	10	Үгүй	ХБ	"Шүгэл" ажиллагааны хүрээнд АТГ-аас зохион байгуулж байгаа "Авлигын эсрэг нэгдье" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын цахим сайтад авлигын талаарх гомдол мэдээллийг хүлээн авах 110 утас, мэдээллийн самбарт холбогдох мэдээ мэдээллийг сурталчилж ажиллалаа.